

ЛООЛЬ

Ач холбогдол:



А, С, В1, В2 амин дэм болон калийг их хэмжээгээр агуулдаг. Тогтмол хэрэглэбэл цус багадах, амин дэм С дутагдсанаас үүсдэг төрөл бүрийн өвчнөөс урьдчилан сэргийлэнэ.

Сорт. Эрт болцтой сортын ургац 90-120 хоногт гүйцдэг. Манай орны нөхцөлд эрт болцтой Грунтовой грибовский—1180, Сибирский скороспелый сортууд тохиромжтой.

Ургах нөхцөл. Үржил шим сайтай хөнгөн шавранцар хөрсөнд сайн ургана. Үр нь 10-15 °С-д ургаж эхлэнэ. Үрийг хөрсөнд суулгаснаас хойш 7-10 хоногт соёолно. 25-27°С-ийн дулаан, 75-80%-ийн агаарын харцангуй чийгтэй нөхцөлд хэвийн ургана. Хасах температурыг тэсвэрлэдэггүй.

Хөрс боловсруулалт. Ил талбайд тарихад хөрсийг 1 м.кв талбайг 8-9 кг ялзарсан бууцаар бордож 25-30 см гүн хагалж өвөлжүүлээд хавар хөрс +15°С халсан үед сайн тэгшилж чулуу хогийг түүж аваад дахин сийрүүлэлт хийсний дараа тарина. Хүлэмжинд тарих бол хөрсийг 40-50см гүн боловсруулж дээрхи нормоор бордоно.

Тарилт: Ил талбай ба хүлэмжинд үрээр ба үрслэгээр тарина. Говийн бүсээс бусад бүс нутагт заавал үрслэгээр тарина. Харин говийн бүсэд эрт болцтой сортыг үрээр тарьж болно. Лоолийн үрслэгийг 3-р сарын 10-15-ны хооронд ургуулж эхлэнэ.

Үрслэг ургуулах.

Үр дэвтээх	Усанд хийж тасалгааны температурт 2-3 хонуулна.
Үрийг ариутгах	Шүүж аваад 1%-ийн марганцын уусмалд 30 минут байлгана.
Хөрс бэлтгэх	Багсармал бордоо ба бүрэн ялзарсан бууц, нуранги элс / шаваргүй элс/, хар шороог 30:30:40 хэмжээтэй холиод хайрцаг ба хоовондоо хийж услана.
Үр суулгах	Үрийг 5х 5 см зайтайгаар нэг үүрэнд 2-3 ш –ээр 1 см гүнд суулгаад нийлэг хальсаар бүтээж дулаан байранд тавина.
Арчилгаа	70% нь соёолох үед хучлагыг авч гэрэл сайтай газар байрлуулна. Соёололтын эхэн үед гэрэл дутагдвал үрслэг сунаж цаашид ургах чадваргүй болдог. Хөрс 1см-ээс илүү хатах үед тогтмол усалгаа хийж байх хэрэгтэй.

Үрслэгийг шилжүүлэх. 7-9 навчтай бахим бүдүүн иштэй 40-өөс дээш хоногийн настай болсон үрслэгийг тухайн бүс нутагт хаврын эцсийн хүйтрэлт болсоны дараа ил талбай ба хүлэмжийн талбайд 50х50 см зайтайгаар шилжүүлэн суулгаж ургамал бүрийг 2-3 л усаар услана.

Ээлжлэн тариалалт: Хэрвээ хүлэмжинд тарьж байгаа бол талбайн хөрсийг 2 жил тутамд солих хэрэгтэй. Ил талбайд бол төмснөөс бусад ямарч тарималын дараа тариалж болно.

Усалгаа. Хөрсний хээрийн чийгийн багтаамж 70-80% агаарын харьцангуй чийг 75-80%-тай нөхцөлд илүү тохиромжтой ургана. Энэ нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хөрсний өнгөн хэсэг 1 см орчим хатсан тухай бүрт 1 м кв талбай бүрт 30-40 л ус орохоор тооцож услаад усалгаа бүрийн дараа хөрсийг сийрүүлж ишийг манаж өгнө. Ишийг манаснаар нэмэлт үндэс үүсэж ургамлын ургалт эрчимжинэ. Хөрсний чийг багасвал ургалт нь зогсож цэцэг жимс нь унаж эхлэнэ. Агаарын болон хөрсний чийг их бол жимсний үзүүр илжрэх, навчний толбожилт, фитофтор зэрэг өвчнөөр өвчилөхөөс гадна тоос хүртэлт муу явагдаж ургац буурна. Ингэхлээр усалгааны тоо нь тухайн бүс нутгийн хөрс цаг уурын нөхцөлөөс шалтгаална. Хэтэрхий халуун бас чийгээ амархан алдагддаг элсэрхэг хөрстэй бүс нутагт усалгааны хоорондын зайг ойртуулж 2-3 хоногт нэг удаа, сэрүүн үед усалгааны хоорондын зайг холдуулах зэргээр усалгааг тохируулна. Хамгийн гол нь хөрсний өнгөн хэсэг хэр их хатаж байгааг л сайн ажиглаж байх хэрэгтэй.

Арчилгаа. Ургалтын үеийн 2-р хагасаас эхлэн лоолийг калийн бордоогоор бордож жимсний боловсролтыг түргэсгэдэг. Калийн бордооны оронд аргалын үнсийг нэг бутанд 1 кг-аар тооцож бордож болно. Лоолийн хамгийн чухал арчилгааны нэг нь таналт байдаг. Таналтыг хийхгүй бол хөрснөөс авах тэжээлийн бодис үр дүнгүй зарцуулагдаж жимсний боловсролт удааширдаг. Таналтыг зөв хийснээр жимсийг богино хугацаанд томруулж болцыг гүйцээнэ.



Лоолийг 1-2 ишээр ургуулж ишний навчны өврийн нахианаас гарсан салааг тасалж авахыг таналт гэнэ. Энэ нь ишнээс хажуу тийшээ салаа ургуулахгүй гэсэн үг. Ингэж танаж ургуулаад гол ишин дээр 8-9 баг цэцэгтэй болсон үед ургах шовгорын нахиаг /ургаж буй үзүүрийг / тайрна.

Энэ үед эхний жимс улайж эхлэж байдаг. Ингэж ургалтыг хязгаарласанаар сүүлд ургасан баг цэцэгний жимс намар ургац хураах хүртэл бүрэн боловсрох нөхцөл бүрдэнэ.

Хураалт. 1м.кв талбайгаас 4кг ургац авна. Лоолийн жимсний 20 % нь улайсан үеэс түүвэрлэн хурааж худалдаанд гаргана. Хэрэв хол тээвэрлэхээр бол дөнгөж ягаарч эхлэх үед хурааж битүү саванд хийж тээвэрлэнэ. Намар улайж амжаагүй жимсийг бүрэн хурааж аваад битүү саванд хийж тасалгааны температурт 14-21 хоног хадгална. Ингэхэд ихэнх нь улайх ба улайгаагүй ногоон жимсийг алаг салат, варень хийхэд ашиглана.